# JOBka аппликэшныг ашиглах

1.JOBka юунд хэрэгтэй вэ?

2.JOBka аппыг хэрхэн татах вэ?

3.JOBka-д хэрхэн бүртгэл үүсгэх вэ?

4.JOBka-г хэрхэн ашиглах вэ?

5.JOBка-д юу байдаг вэ? + ашиглах дүрэм, нөхцлүүд

6.JOBka-г ашиглаж чадахгүй бол надад хэн туслах вэ?



# JOBka юунд хэрэгтэй вэ?

✅JOBka-гийн тусламжтайгаар хэдийд ч мэдээлэл авч болно.

✅Бүхий л урамшууллын талаарх мэдээллийг нэг дороос авч байх болно. Ямар хөнгөлөлт авч болох, таны хөнгөлөлт авах эрх хэр зарцуулагдаж буйг мэднэ.

✅ Ажлын байр хаана байгааг олж мэдэх боломжтой. Мөн шинэ хүнийг ажлын байранд бүртгүүлж шагнал авч болно.

✅ Асуух зүйл байна уу? Асуултаа бичээд хариултыг шууд аппликэшнээрээ авч болно.

✅ Үйлдвэрийнхэнтэйгээ амар хялбар байдлаар бараа солилцох, худалдан авч, зарж болно!

✅ Үйлдвэрийн хоолны танхимын өдөр тутмын хоолны цэс таны гарт.

✅ Таны санал бодол бидэнд чухал! Зохиогдох арга хэмжээнүүдэд оролцож, мөн уншиж мэдсэн зүйлийнхээ талаар санал бодлоо илгээж байгаарай.



FOXCONN

# JOBka-г хэрхэн татах вэ?

JOBka аппыг Google Play эсвэл App Store системээс татаж болно. Утсандаа хайж олоод татахад хангалттай.

JOBka аппыг Google Play эсвэл App Store системээс татаж болно. Утсандаа хайж олоод татахад хангалттай.

App Store

Google Play

# Өөрийн JOBka бүртгэл хэрхэн үүсгэх вэ?

myFox-д нэвтрэнэ




myFox нууц үгээ мартсан бол LEXI-д утасдаарай 800 44 55 77.

myFox – үндсэн хуудас




JOBka лого дээр дарна.

QR кодыг сканэрдэж бүртгэлийг дуусгана

JOBka-д бүртгүүлэх код хүн тус бүрд ирнэ.



FOXCONN

# QR код хэрхэн авах вэ?

1a myFox –д нэвтрэнэ (QR kód)

1b Үйлдвэрийн ID дугаараа оруулна: **foxconnczs**




2.




3.




4.




ID дугаараа бичээд QR кодыг сканэрдэнэ

FOXCONN

# JOBка-гийн сайн талууд юу вэ?

| | |
|---|---|
| **Хамгийн бага шаардлага тавьдаг** | Android 7 ба түүнээс дээшхи шинэ, iOS 11 ба түүнээс дээшхи шинэ загварын ухаалаг утаснууд. |
| **Байрлал тогтоох** | Энэ апп байрлал илрүүлдэггүй. Зөвхөн сайн дурын үндсэн дээр жишээ нь цаг агаарын мэдээлэл авах зорилгоор өөрөө тохиргоо хийж болно. |
| **Аппликэшний хэмжээ** | 15 ш гэрэл зурагтай тэнцэх хэмжээний зай гар утсанд эзлэнэ. |
| **Хамгаалалт** | PIN, ID, Touch ID оруулж болно. |



FOXCONN

# JOBka-г хэрхэн ашиглаж болох вэ?



**<u>JOBka-г ашиглах үедээ:</u>**

✅ хууль эрхзүйг мөрдөнө;

✅ Компанийн Ёс зүйн журмын дагуу хэрэглэнэ;

✅ Компанийн Дотоод журмыг мөрдөнө (гол нь аюулгүй ажилагааны журам);

✅ Компанийн эрх ашиг, сонирхлыг харгалзана.

# JOBка-д юу байх вэ? + Дүрэм, нөхцөлүүд

» **Мэдээ мэдээлэл дамжуулах:** Компанид болж буй үйл явдлын мэдээлэл.

Эдгээр мэдээлэл зөвхөн компанийн ажиллагсдад зориулсан тул гадагш тараахгүй байх.

» **Манай урамшууллууд:** урамшуулал хөнгөлөлтийн талаарх мэдээллийг авч байх болно.

Хөнгөлөлт урамшууллын талаарх мэдээллийг зөвхөн шинэ ажилтан оруулахтай холбоотойгоор гадны хүнд сонирхуулж болно.

» **Асуулга, судалгаа: Өөрийн санал бодлоо хэлж компанийн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулаарай.**

Асуулгад оролцох нь сайн дурын хэрэг бөгөөд хэрэглэгч ямар ч асуулгад хариулахгүй ч байж болно. Ил тод асуултад хариулах хэрэг гарвал **соёлтой, зохистой хариулж бүдүүлэг үг хэрэглэхгүй, хувийн эмзэг мэдээлэл оруулахгүй байх** ёстой.



# JOBка-д юу байх вэ? + Дүрэм, нөхцөлүүд




» **Хоолны цэс:** Үйлдвэрийн хоолны өдөр тутмын хоолны цэс.

» **myFOX: Хүний нөөцийн систем рүү орж болно** (нэвтрэх нэр шаардана).

» **Миний JOBka ертөнц:** Хамтран ажиллагч, нийлүүлэгч компаниудын модуль болон уг аппыг ашиглах талаарх манай компанийн дүрэм байх болно.

» **Хувийн мэдээллийн зөвшөөрөл:** UАппликэшн анх хэрэглэж эхлэхдээ уг зөвшөөрлийг өгнө. Энэ зөвшөөрөлгүйгээр аппликэшнийг ажиллуулах боломжгүй.

Зөвшөөрөл өгснөөр уг аппыг ашиглах нөхцөл болзлыг, модуль тус бүрийн дүрэм болон хувийн мэдээлэлтэй харьцахыг зөвшөөрч байна гэсэн үг.

» **Тохиргоо:** Хэл, эсвэл PIN код сольж болно.

# JOBка-д юу байх вэ? + Дүрэм, нөхцөлүүд

» **Ажлын байрны санал:** Нээлттэй ажлын байрны зар, шинэ ажилтан санал болгох маягт.

Шинэ ажилтан оруулах нөхцөлийг **зөвшөөрөх** хүнийг зөвхөн ажлын байранд санал болгоно (зөвшөөрлийн загвар бичгийг аппликэшний маягт гэсэн хэсэгт үзнэ үү). Тухайн ажлын байрны нөхцөл шаардлагыг биелүүлж чадах хүнийг ажлын байранд санал болгоно.

» **Асуугаарай:** Хэлтэс бүрээр асуултыг төрөлжүүлнэ.

Асуултыг **нэрээ нууцлахгүйгээр** бичнэ, админууд асуултын эзний нэр овог, ID дугаарыг харж байх ёстой.

Асуултыг соёлтой, тодорхой, бодитойгоор бичнэ.

Асуултад **бизнес үйл ажиллагаатай холбоотой нууцлаг эмзэг мэдээлэл** оруулахгүй байх ёстой. Яагаад гэвэл, аппликэшний бүх админд харагддаг (жишээ нь, EHS, ICT, PR, IT зэрэг)



# JOBка-д юу байх вэ? + Дүрэм, нөхцөлүүд




» **Зах:** Үйлдвэрийнхэнтэйгээ бараа солилцох, худалдан авч, зарж болно.
Энэ захад **зөвхөн үйлдвэрийн ажилчид** оролцоно.

Зар мэдээ, зураг тавихдаа **гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөхгүй байх** ёстой. Санал болгож буй бараа, үйлчигээний талаарх үнэн зөв мэдээллийг тавих үүрэгтэй.

Ажилтан хөдөлмөрийн харилцаа дуусгавар болгосон тохиолдолд 5 хоногийн дотор Захаас зар мэдээ нь автоматаар устана.

Зар мэдээнд тавьсан холбогдох утас, имэйл хаяг зэргээр зар тавигчтай холбогдож болно. Мөн коммэнтоор бичиж болно.

Зар мэдээнд тавигдсан бараа үйлчилгээний **чанар, гарал үүсэл зэргийн талаарх ямар ч хариуцлагыг компани хүлээхгүй.** Зар тавигч болон сонирхогч хоорондын харилцаа нь иргэний хуулиар зохицуулагдана. Бараа, үйлчилгээг хүргэх, дамжуулах, төлбөр хийх зэргийн хариуцлагыг зар тавигч болон сонирхогч өөрсдөө хариуцна.

Зар мэдээ оруулахад тавигдах шаардлага нөхцөлийг биелүүлээгүй, хууль эрхзүйн болон компанийн дүрэм журмыг зөрчиж буй зар мэдээллийг "Зах" модульд компани  оруулахгүй байх эрхтэй.

**Хориотой зүйлс бичих:** Хориотой эсвэл хууль бус бараа үйлчилгээ, бизнес үйл ажиллагаа, **компанийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, материал, эд анги санал** болгосон зар мэдээ байж болохгүй.; Тодорхой мэдээллийг Аппликэшн ашиглах нөхцөлүүд хэсгээс үзнэ үү.

# JOBka-г ашиглахад хэн надад туслах вэ?

Аппликэшний техникийн алдаа гарвал (ж нь, ажилтны хувийн аккаунттай холбоотой) ➡ JIRA ticket –ээр дамжуулан HRIS хэлтэс

Аппликэшний талаарх мэдээлэл, санал гомдол ➡ Irena Tomková, Zuzana Bittner

Аппдикэшнд алдаа гарах ➡ Můj Jobka svět






FOXCONN